



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/306

Улаанбаатар хот

Өрийн хэрэгсэл бүртгэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.11.5 дахь заалтууд, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/764 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржээр 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр арилжигдсан Нийслэлийн Засаг даргын гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 24 сарын хугацаатай, 1,000,000 ширхэг, 3047 (MUB) кодтой "Улаанбаатар бонд II" өрийн хэрэгслийн төлбөр бүрэн төлөгдсөн тул "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлээс хассугай.

2. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороонд, холбогдох мэдэгдлийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид тус тус хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.

3. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-т, цахим хуудас болон арилжааны системд холбогдох өөрчлөлт хийхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.МӨНХБАТ



1526035627

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН
БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ
№3047**

Хэнд: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д

Огноо: 2026/06/20

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас хадгаламжаас хасах тухай
Үндэслэл:	“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026.06.20 -ны өдрийн 1/306 тоот тушаал, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК -ийн 2026.06.26-ны өдрийн 01/764 тоот албан бичиг
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл
Үнэт цаасны нэр:	Улаанбаатар бонд II
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/	MUB, 3047
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	1,000,000 /нэг сая/ ширхэг
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100,000 /нэг зуун мянга/ төгрөг
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	100,000,000,000 /нэг зуун тэрбум/ төгрөг
Үнэт цаасны хугацаа: /долоо хоног, сар/	2 жил
Үнэт цаасны хүү / өгөөжийн хувь хэмжээ:	Жилийн 13%
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа: /давтамж/	Хагас жил тутам
Үнэт цаас арилжигдсан өдөр	2024.06.20
Үнэт цаасны хугацаа дуусах огноо	2026.06.25

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ